



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Үнэт цаас бүртгэлээс хасах тухай

СЗХ-ны 2014 оны 04-р сарын 09-ний өдрийн 113 тоот тогтоол, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 58, 59.1-р заалт, “Дархан-Импекс” ХК-ийн 2014 оны 04-р сарын 23-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайланг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. “Дархан-Импекс” ХК-ийн гаргасан нийт 668,572 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хассугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “ҮЦГТТХТ” ХХК-д хадгаламжаас хасах мэдэгдэл хүргүүлэхийг Бүртгэлийн албаны менежер /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
3. “Дархан-Импекс” ХК-ийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, МХБ-ийн бүртгэлээс хасагдсан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг мэдээллийн албаны мэргэжилтэн /Д.Өлзийбат/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БОЛОРМАА

2014 оны 05-р сарын 9

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-Д**

ҮНЭТ ЦААС ХАДГАЛАМЖААС ХАСАХ МЭДЭГДЭЛ № 367-д

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 04-р сарын 09-ний өдрийн 113 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 05-р сарын 9-ны өдрийн № 65 тоот тушаалыг тус тус үндэслэн “Дархан-Импекс” ХК-ийн гаргасан нийт 668,572 ширхэг хувьцааг Төвлөрсөн хадгаламжаас хасахыг мэдэгдье.

ҮЗҮҮЛЭЛТ		БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ
Үнэт цаасны нэр :		“Дархан-Импекс” ХК
Үнэт цаасны үсгэн код:		DRI
Үнэт цаасны төрөл:		Хувьцаа
Үнэт цаасны тоо /ширхгээр/		668,572
Үүнээс:	тоо /ширхэг/	0
Төрийн эзэмшил	хувь /%/	0%
Олон нийтийн	тоо /ширхэг/	668,572
Эзэмшил	хувь /%/	100%
Үнэт цаасны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		100
Үнэт цаасны нийт үнийн дүн /төгрөгөөр/		668,572

МХБ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

МХБ-ИЙН БА-НЫ МЕНЕЖЕР



Д.БОЛОРМАА

М.ЭНХТУЯА